



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/96

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.9.3, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.2 дох заалт болон “Хүннү эмпайр ҮЦК” ХХК-ийн 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн №16/2024 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/282 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрхийг нь хязгаарлсан “Хүннү эмпайр ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанитай байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлж ажиллахыг “Хүннү эмпайр ҮЦК” ХХК /Т.Аззаяа/-д анхааруулсугай.
3. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрх сэргээхийг Үйл ажиллагааны газрын Арилжааны албаны ахлах мэргэжилтэн /Д.Алдармаа/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний албаны ахлах мэргэжилтэн /Д.Баттулга/-д тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЦОГТБАЯР

1524030171